# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр Дугаар 424 Улаанбаатар хот

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд тодотгол хийж хавсралт ёсоор батлсугай.

2.Үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний тодотголд үндэслэн бизнес болон худалдан авалтын төлөвлөгөөний тодотголыг баталж төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлагыг бууруулах талаар арга хэмжээ авах, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Алтанцэцэгт үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001437

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 424 дугаар
тогтоолын хавсралт

**"СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН**
**2021 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛЫН САНАЛ**

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2019 оны гүйцэтгэл | 2020 | | | | Харьцуулалт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Тодотгол | 2021 оны тодотгол/2021 оны төлөвлөгөө | 2021 оны тодотгол-2021 оны төлөвлөгөө |
| 1 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | | | | | | | | |
| | а/ Гол нэр төрлөөр | мян.төг | - | - | - | | | | |
| | б/ Үнийн дүнгээр | мян.төг | 852,405.9 | 1,289,000.0 | 653,083.9 | **1,120,000.0** | **489,000.0** | 0.44 | (631,000.0) |
| 2 | Нийт орлого | мян.төг | 852,405.9 | 1,289,000.0 | 653,083.9 | 1,120,000.0 | 489,000.0 | 0.44 | (631,000.0) |
| | Үүнээс: Цэвэр борлуулалтын орлого | мян.төг | 843,452.0 | 1,281,804.0 | 629,765.8 | 1,097,094.5 | 451,480.0 | 0.41 | (645,614.5) |
| | Түрээсийн орлого | мян.төг | 7,920.0 | 7,196.0 | 23,318.1 | 22,905.5 | 37,520.0 | 1.64 | 14,614.5 |
| 3 | Нийт зардал | мян.төг | 1,005,669.7 | 1,242,481.3 | 732,494.8 | **1,044,197.7** | **489,000.0** | 0.47 | (555,197.7) |
| | Үүнээс:Удирдлагын зардал | мян.төг | 58,802.0 | 75,952.7 | 63,398.0 | 64,125.2 | 64,125.2 | 1.00 | 0.0 |
| 4 | Татварын өмнөх ашиг /алдагдал/ | мян.төг | (153,263.8) | 46,518.7 | (79,410.9) | 75,802.3 | - | - | (75,802.3) |
| 5 | Цэвэр ашиг/алдагдал/ | мян.төг | (153,357.1) | 41,866.8 | (79,013.8) | 68,222.0 | - | - | (68,222.0) |
| 6 | Ногдол ашиг | мян.төг | 10,000.0 | 60,075.6 | 44,621.0 | 130.0 | - | - | (130.0) |
| 7 | Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал | төг | 1.2 | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 | 0.96 | (0.0) |
| 8 | Хөрөнгө оруулалт | мян.төг | 57,390.1 | 190,563.6 | - | 277,404.0 | | - | (277,404.0) |
| 9 | Нийт авлага | мян.төг | 268,793.8 | 73,423.9 | 243,736.6 | 74,277.3 | 213,894.7 | 2.88 | 139,617.4 |
| | Үүнээс: 0-5 жилийн насжилттай | мян.төг | 197,308.8 | 27,024.2 | 179,754.5 | 38,549.3 | 157,224.7 | 4.08 | 118,675.4 |
| | 5-10 жилийн насжилттай | мян.төг | 71,485.0 | 46,399.7 | 63,982.1 | 35,728.0 | 56,670.0 | 1.59 | 20,942.0 |
| 10 | Нийт өглөг | мян.төг | 292,127.8 | 83,596.0 | 350,086.7 | 89,506.9 | 393,157.7 | 4.39 | 303,650.8 |
| | Богино хугацаат өр төлбөр | мян.төг | 292,127.8 | 83,596.0 | 350,086.7 | 89,506.9 | 393,157.7 | 4.39 | 303,650.8 |
| | Урт хугацаат өр төлбөр | мян.төг | - | | | | | | - |
| 11 | Нийт ажиллагсдын тоо | хүн | 39 | 39.0 | 39 | 39 | 39 | 1.00 | - |
| 12 | Нийт цалингийн сан | мян.төг | 380,162.0 | 453,514.8 | 255,855.0 | 384,610.8 | 259,480.0 | 0.67 | (125,130.8) |
| 13 | Нэг ажиллагчийн дундаж цалин | мян.төг | 1,056.0 | 969.00 | 852.9 | 902.8 | 618.6 | 0.69 | (284.3) |